

**“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 04 сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 10 цаг 05 минутад компанийн байранд цахим хэлбэрээр/онлайнаар явагдаж эхлэв.

“БиДиСек ҮЦК” ХК нь нийт саналын эрх бүхий 13,694,883 ширхэг хувьцаатай. Үүнээс компанийн 100% эзэмшдэг Би Ди Си Эй Пи ХХК - охин компанийн 412,598 ширхэг энгийн хувьцаа нь КТХ 6.10-т зааснаар саналын эрхгүй болно. Иймээс БиДиСек ҮЦК ХК нь нийт 13,282,285.00 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаатай болно.

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт саналын эрх бүхий хувьцааны 82.89 хувь буюу 11,009,864 ширхэг хувьцаа эзэмшиж буй 24 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурал эхлэв.

“БиДиСек ҮЦК” ХК-ийн хурлын дарга Бүрэнмэнд овогтой Лхагвадорж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээн, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц:

- ҮЦК-иар дамжуулан саналын хуудсаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	Төрөл
1	Impera Mongolia Holding	755,000	5.68%	саналын хуудсаар
2	Zwahr Alexander	3,356,312	25.27%	саналын хуудсаар
3	Хитоши Тани	309,091	2.33%	саналын хуудсаар
4	Daniel Paul Stein	258,874	1.95%	саналын хуудсаар
	Нийт	4,679,277	35.23%	

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналаа цахим саналаар өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	Төрөл
1	Б.Энхбаяр	100	0.00%	Цахим саналаар
2	С.Дамдинсүрэн	269	0.00%	Цахим саналаар
	Нийт	369	0.00%	

- Итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналаа өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	Төрөл
1	М.Молор	2	0.00%	саналын хуудсаар
	Нийт	2	0.00%	

- Компанийн байранд өөрийн биеэр ирж ирцээ баталгаажуулан хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын хуудсаа өөрийн биеэр авчирч өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	Төрөл
1	Монголиан Мастер Менежмент	1,054,301	7.94%	саналын хуудсаар
2	Тасган Инвест	1,606,938	12.10%	саналын хуудсаар
3	Д.Эрдэнэчимэг	14,352	0.11%	саналын хуудсаар
4	С.Пүрэвсүрэн	3,732	0.03%	саналын хуудсаар
5	Эм И Ти Эф ХХК	360,678	2.72%	саналын хуудсаар
6	Д.Даянбилгүүн	2,449,344	18.44%	саналын хуудсаар
7	Б.Лхагвадорж	476,659	3.59%	саналын хуудсаар
8	С.Уранчимэг	5	0.00%	саналын хуудсаар
9	Д.Энхтуяа	10	0.00%	саналын хуудсаар
10	Н.Батгэрэл	338,014	2.54%	саналын хуудсаар
11	Д.Ихтөгөлдөр	5,299	0.04%	саналын хуудсаар
12	Д.Тэнүүн	5,431	0.04%	саналын хуудсаар
13	Ш.Шинэбаяр	2,707	0.02%	саналын хуудсаар
14	О.Уранбайгаль	881	0.01%	саналын хуудсаар
15	Ш.Бүүвэйбаатар	272	0.00%	саналын хуудсаар
16	Х.Сурмаа	90	0.00%	саналын хуудсаар
17	Д.Дайчинбаатар	11,503	0.09%	саналын хуудсаар
	Нийт	6,330,216	47.67%	

Хурлаар хэлэлцсэн асуудлуудын жагсаалт:

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
- Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-н гаргасан шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ийн 2020 оны төсөв батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 82.89% буюу 11,009,864 ширхэг хувьцаа эзэмшиж буй 24 хувьцаа эзэмшигчдийн саналыг авсан ба үүнээс 4,679,277 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч ҮЦК-иараа дамжуулан, 369 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч цахимаар, 6,330,218 ширхэг хувьцаа эзэмшиж буй 18 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саналаа ирүүлсэн.

Кумулятив аргаар өгөх саналын эрх: 99,088,776 /нийт хувьцааг х 9/.

Хувьцаа эзэмшигчид дараах асуудлуудад ердийн аргаар санал өгөв:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
3. ТУЗ-ийн 2020 оны төсвийг хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.

Хувьцаа эзэмшигчид дараах асуудалд кумулятив аргаар санал өгөв:

4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд өгсөн санал:

Ердийн гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Д.Даянбилгүүн	23.2878%
2	Б.Лхагвадорж	23.2852%
3	Н.Батгэрэл	23.2852%
4	Улуч Бингол	30.1419%

Хараат бус гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Жеймс Кристофер Пассин	19.9996%
2	Хитоши Тани	19.9995%
3	Д.Амгаланбаяр	19.9995%
4	Б.Энхбаяр	19.9995%
5	Б.Амарсанаа	20.0019%

тус тус санал авч, ТУЗ-ийн гишүүд сонгогдов.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гасан тогтоолын шийдвэрийг 10 цаг 52 минутанд танилцуулан дуусч, хурлын дарга хурлыг хаав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Хурлын дарга:



/ Б.Тэмүүлэн/
/Б.Лхагвадорж/